

БОЛОВСРОЛЫН ФИЛОСОФИЙН ТУХАЙ

Т.НЭМЭХЖАРГАЛ
МУБИС, ТНУС, НУ-ны тэнхим

Түлхүүр үг: философи, эргэцүүлэл, боловсрол, үнэлэмжийн ертөнцийн хөгжил, төлөвшил, боловсролын философийн үүрэг, зорилго.

Товч утга: Нийгмийн хөгжлийн тодорхой эрин үе бүхэн өөрийн онцлогийг хүн төрөлхтөнд мэдрүүлж ирсэн бөгөөд боловсролын философийн үүсэл, хөгжил ч бидний амьдарч буй энэ эрин үеийн дуудлага, захиалга байв. Философийг философчид нь олон янзаар тайлбарлагдгийн нэгэн адил боловсролын философийн талаар бас л олон янзын үзэл баримтлал байдаг. Ингээд боловсролын философийн асуудлаар өөрийн үзэл, эргэцүүллийг толилуулж байна.

Боловсролын асуудал өнөөдөр зөвхөн тухайлсан нэг орны төдийгүй олон улсын хэмжээнд чухлаар тавигдаж байгаа билээ. Нийгмийн хөгжлийн аливаа өөрчлөлт шинэчлэлт өөрийн философи үндэслэгээг шаардаж байдаг. Боловсролын салбарт хуримтлагдсан асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг эрж сүвэгчлэх нь боловсрол хэмээх үйл явцын философи үндэслэгээг эргэн харж нягтлахыг шаардсан хэрэг мөн билээ. Нэн ялангуяа, боловсролд оногдож буй хариуцлага хамрах хүрээ, ач холбогдлоороо глобаль шинж хандлагатай болж буй өнөө үед түүний философи асуудлыг эргэцүүлэхгүйгээр амжилтанд хүрнэ гэдэг байж боломгүй зүйл гэдгийг дээрх асуудалд сэтгэл оюунаа зориулан буй манай зарим судлаачид, эрдэмтэд сонордуулсаар байгаа хэдий ч энэ чиглэлийн судалгаа шинжилгээ манайд хомс байгааг тэмдэглэмээр байна. Өөрөөр хэлбэл, боловсролын асуудал эдүгээ философидолтонд дуудаж буй чухал сэдэв болж байгаа билээ.

Нийгмийн хөгжлийн тодорхой эрин үе бүр өөрийн онцлогийг хүн төрөлхтөнд мэдрүүлж ирсэн бөгөөд, энэхүү онцлог нь тухайн эрин үеийн философийн эргэцүүллийн манлайд явж ирсэн байдаг. Боловсролын философийн үүсэл, хөгжил нь бидний амьдарч буй эрин үеийн онцлог болсон амин чухал асуудлуудтай зүй ёсоор холбогддог.

20-р зууны дунд үеэс өрнөсөн соёл иргэншлийн хямрал нь философийн аксиологи хандлагыг эн тэргүүнд тавьж, хүний үнэлэмжийн ертөнцийн хөгжил төлөвшлийн асуудлыг зонхилох байр суурьтай авч үзэхэд хүргэсэн билээ. Эдүгээ соёл, шинжлэх ухааны үнэт зүйлсийг өөриймшүүлсэн, ухаалаг, өөртөө итгэлтэй, бие даасан, бүтээлч хүнийг эрхэмлэх болов. Энэ эрин үеийг боловсролын зуун гэж хүртэл нэрлэж

МУИС Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль

байна. Шинжлэх ухаан техникийн эрин үе гэж бид бахархан уншиж, бичиж байсан нь саяхан билээ. Боловсролын дүр төрх, боловсролын үнэлэмж, эрхэмнэлүүдийн тухай асуудал философид цаг ямагт эргэцүүлэгдэж ирсэн боловч чухамхүү "боловсролын философи" хэмээх философийн бие даасан салбар ухааны тухай өнгөрсөн зууны хоёрдугаар хагасаас ярьж эхэлсэн. Энэ үйл явцын эхлэл нь 20-р зууны 40-өөд оны үед Колумбийн их сургуульд боловсролын философи асуудлыг тусгайлан судлах салбар байгуулагдсан явдал байлаа.

Өнөөдөр боловсролыг хүний жам ёсны эрх, орших аргын хэмжээнд авч үзэж байна. Боловсролд ийм шинж хандлага, зорилго урьд өмнө хэзээ ч оногдож байгаагүй гэж хэлж болно. ЮНЕСКО, Даян Дэлхийн Ирээдүйн Нийгэмлэг, НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр зэрэг олон улсын соёл, боловсролын нэр хүндтэй байгууллагуудын хүрээнд боловсролын асуудал тогтмол хэлцэгдэх болж, хүн төрөлхтний ирээдүй, глобаль асуудлуудыг шийдвэрлэх арга замыг гагцхүү боловсролтой холбож тайлбарлаж байна.

Орчин үед боловсролын философи нь барууны улс орнуудад философийн мэдлэгийн чухал салбар болон хөгжиж байна. Манай улсад ч боловсролын философи асуудлаар судалгаа шинжилгээний бүтээлүүд гарч буй хэдий ч энэ асуудлаар философчидын дунд семинар, симпозиум зохиох явдал хэвшил болж чадаагүй байгаа нь харамсалтай. Посткоммунизмын орнууд өнгөрсөн зууны ерээд оноос эхлэн боловсролын философийн асуудалд онцгой анхаарах болсноор эдүгээ энэ чиглэлийн судалгаа шинжилгээ өөрийн гэсэн өнгө төрх, бүтэц байгууламжтай болж чаджээ

Боловсролын философийн мөн чанар, зорилгыг авч үзэх нь юуны түрүүнд философийг хэрхэн ойлгож байгаагаас хамаарна. Философийг тодорхойлох тухай асуудал өнөө үед ч өргөн хэлэлцүүлгийн сэдэв байсаар байгаа билээ. Уг асуудлаар философчдын дунд гурван үндсэн чиг шугам ажиглагдаж байдаг. Нэгдэх чиг шугамыг баримтлагчид философийг шинжлэх ухаан мөн гэж тодорхойлдог. Энэхүү чиг шугамыг Милетийн сургуулийнхан, Демокрит, Платон, Аристотель нар дэвшүүлж байсан бөгөөд хожим нь Бэкон, Дидро, Гельвеций, Гегель, Маркс зэрэг философчид үргэлжлүүлэн хөгжүүлжээ. Тэрээр философийн гол судлагдхууныг гадаад ертөнцийг (байгал, нийгэм, хүн) танин мэдэх тухай асуудал гэж тодорхойлдог. Философи бол хүн өөрийгөө танин мэдэх арга бөгөөд ертөнцийг биш, харин түүнд хандах хүний харилцааг судалдаг гэх хоёр дахь чиг шугамын хувьд философи нь хүний ертөнцийг үзэх үзлийн чиг баримжааг тодорхойлж өгдөг. Иймээс философийг шинжлэх ухаан биш

гэж үздэг. Энэ чиг шугамыг Сократ болон стоичууд баримталж байсан ба хожим экзистенциалист чиглэлийнхэн тэргүүтэй залгамжлан хөгжүүлжээ.

Гурав дахь чиг шугам нь философийг шинжлэх ухаан мөн, эсвэл биш гэж хатуу зааглах оролдлого нь философийн тухай иж бүрэн төсөөлөл бий болоход сөргөөр нөлөөлнө гэсэн үзэл юм. Ийм үзлийг орчин үеийн нөлөө бүхий олон философчид баримталж байна. Философи шинжлэх ухаан мөн эсэх тухай асуудал нь өнөөдөр философийн тулгамдсан сэдэв байхаа больсон гэж үздэг бөгөөд түүнийг шинжлэх ухаантай харилцан холбоотой оршдог, мэдлэгийн бие даасан тогтолцоо, өвөрмөц төрөл гэсэн санааг иш үндэс болгодог. Шинжлэх ухаан ба философийн хооронд нийтлэг зүйл ч бий, бас үл нийцэх зүйл ч бий гэж үздэг.

Энэхүү сүүлчийн үзлээс ургуулан философийн мөн чанар онцлогийг дараах байдлаар илэрхийлж болох юм.

1. Философи бол хүний ахуйг эзэмдэгч нийтлэг асуудлуудад хариулт өгөх эргэцүүлэл, рефлекси яах аргагүй мөн. Түүний үүсэл, хөгжил ч үүнийг гэрчилнэ. Гэхдээ энэ нь яав ч шинжлэх ухаанаас гадуур ямар нэг дур зоргын шинжтэй зүйл биш, харин эргэцүүллийн онолжсон хэлбэр гэж үзэж болно. Онолжсон хэлбэр гэсний утга нь философи бол бусад шинжлэх ухааны нэгэн адил рациональ танин мэдэхүй дээр тулгуурлан, үндэслэл, дүгнэлтээ системтэй гаргадаг. Философи нь өнөөдөр танин мэдэхүйн онол, арга болтлоо хөгжжээ. Тэрээр бусад шинжлэх ухааны ололт, амжилтыг нэгтгэн дүгнэдэг, мөн тэр хэмжээгээрээ тэдгээрийг ашигладаг.

2. Философийг судлах гэдгийн дор гадаад ертөнцийн тухай асуудлыг биш, харин ертөнц дэх хүний оршихуйн талаарх онолын эргэцүүлэл, мэдлэгийг судлах явдлыг ойлгож болох юм. Философи гэдэг нь ийм онолын эргэцүүлэл, мэдлэгийн систем бүтээж буй үйл ажиллагаа мөн. Тийм болохоор философи нь тодорхой субъектийн үзэл бодлын систем, эргэцүүлэл, сэтгэлгээний логик, сэтгэлгээний соёл, соёлын харилцан ярианы хэлбэрээр хөгжиж байдаг. Эдгээр тодотголууд философийг мөнхөд дагалдаж ирсэн бөгөөд бас философийн олон урсгал, чиглэл зэрэгцэн оршиж байдгийн гэрч билээ.

3. Философийн асуудлууд нь нийт хүн төрөлхтөний хийгээд мөнх шинжтэй. Ийм учраас философийн мэдлэгийн ямар нэг хавсрага ач холбогдол, үүргийн тухай ярих боломжгүй юм. Философи бол амьдралын чиг шугам, оюуныг залах хүч болдог. Тухайлбал, шинжлэх ухааны үйл ажиллагаатай харьцахдаа танин мэдэхүйн арга, онол болж, арга зүйн үүрэг

гүйцэтгэнэ. Урлаг, ёс суртхууны асуудалтай харьцахдаа соёлын болон үнэлэмжийн чиг баримжааны үүрэг гүйцэтгэдэг. Нийгмийн амьдралтай харьцахдаа тэр ерөнхийд нь чиглүүлэх үүргийг гүйцэтгэдэг.

Тэгвэл, боловсролын философийн онцлог юунд орших вэ.? Юуны түрүүн, энэ талаар олон янзын үзэл баримтлал байдгийг тэмдэглэх хэрэгтэй. Тухайлбал, "Боловсролын философийн гол асуудал бол ертөнцийг үзэх үзлийн анхдагч чиглүүлэгч болон соёлыг тодорхойлогч үнэт зүйлсийг ухаарч эргэцүүлэхтэй холбогдсон зарчмын асуудлууд байх юм" (Н.Алексеев, И. Семёнов, В.Швырев Философия образования. Концептуально-методологические средства анализа. (www. URAO.RU); "Энэ ертөнцийн хамгийн ерөнхий онол нь боловсролын философи байх ёстой" (Савицкий И.П. О философии глобального образования., М., 1992.,х.,10); "Боловсролын философи нь сурган хүмүүжүүлэх ухааны суурь үзлүүд болох боловсролын зорилго, эрхэмнэл, боловсролын түүх, боловсролд философийн үзүүлэх нөлөө зэрэг асуудлыг шинээр авч үздэг" (В.М. Розин "Образование в конце XX века" - материалы "круглого стола". Вопросы философии 1992. №9); "Боловсролын философи нь соёлын орчин дахь хүний оюуны болон ёс суртхууны хөгжил, төлөвшил хэрхэн явагддаг, энэ үйл явцад боловсролын систем хэрхэн нөлөөлж болох (нөлөөлөх ёстой) вэ? гэдгийг авч үздэг. Үүнтэй холбоотой гарч ирэх асуудлуудыг хэлэлцэх нь яалт ч үгүй философийн тулгуур асуудалд хандахад хүргэдэг" (Э.Н.Гусинский, Ю.И.Турчанинова. Введение в философию образования., М.,2001. х.,5) гэх мэтээр олон арван тодорхойлолтыг дурдаж болно.

Боловсролын философийг ийнхүү олон янзаар тайлбарлаж байгаа нь философийн дээр дурьдсан онцлогуудтай шууд холбоотой буюу өөрөөр байх аргагүй. Ингээд боловсролын философийг маш товчоор боловсролын асуудалд хийгдэж буй философи эргэцүүлэл гэж үзэж болно. Түүнчлэн боловсролын философийн олон урсгал чиглэлүүд зэрэгцэн оршиж байх нь ердийн хэрэг бөгөөд эдгээрийг нэгтгэж боловсролын "нэг ерөнхий" философи босгох, аль эсвэл нэгийг нь сонгон авч бэлэн жор болгон ягштал баримтална (ийм хандлага байдаг) гэдэг нь боломжгүй зүйл бөгөөд харин тэдгээрээс аль нэгийг нь арай давуу байр суурьтай авч үзэж болох юм. Боловсролын философи нь боловсролыг судалдаг бусад (боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухаан зэрэг) шинжлэх ухаантай харьцахдаа арга зүйн үүрэг гүйцэтгэнэ.

Боловсролын философийн гол зорилго нь а) орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцэх соёлын үнэлэмжүүдийг тодруулах, цаашилбал, хүн

төрөлхтөний тэсэж амьдрахуйн арга, гарцын тухай асуудлыг эргэцүүлэх; б) боловсролын тулгамдсан асуудлууд болон тэдгээрийг шийдвэрлэх арга замыг эрж сүвэгчлэх; хүний тухай үзэл, төсөөлөл, боловсролын утга учир хийгээд соёлын системд эзлэх байр суурь; боловсролын эрхэмнэл, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны мөн чанар, суурь зарчим, онцлогийг авч үзэх; в) сургалтын шинэ, альтернатив хувилбар бодож боловсруулах, хэлэлцүүлэх, боловсролын салбарт хэрэгжүүлэх бодлогыг үндэслэх, боловсролын зорилгыг томъёолох, боловсролын системийн алс хэтийг төлөвлөх, таамаглах зэргээр тодорхойлогдоно.

Боловсролын философи нь философийн сонгодог бус рационализмын зарчмаар, өөрөөр хэлбэл, бодит байдал дахь жинхэнэ асуудалт нөхцөлд нь эргэцүүлэл хийж, боловсролын ерөнхий концепци, чиг шугамыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх хамгийн үр ашигтай арга замыг эрж олох үүрэгтэй.

Боловсролын зорилго, агуулга, эрхэмнэлийг тодорхойлж байсан үзэл суртлын тоталитаризмаас ангижирсан манай улсын хувьд боловсролд баримталж ирсэн үндсэн зарчим, боловсролтой хүний тухай төсөөлөл, сурган хүмүүжүүлэх суурь зарчмын тухай асуудлыг эргэн харах, өөрийн улс үндэстний боловсролыг дэлхийн соёлын интеграцид ойртуулах, боловсролыг ардчилах, тасралтгүй боловсролын тогтолцоог бий болгох, боловсролыг хүмүүнжүүлэх чиг шугамыг чухалчлах, өөрөөр хэлбэл, боловсролын үйл явцад өөрийнх нь жинхэнэ зүй тогтолын дагуу хандах хэрэгцээ шаардлага юунаас ч илүү чухал тавигдаж байна.

Резюме

Выделение и изучение философии образования в качестве особого исследовательского направления у нас началось в конце 90-х годов прошлого века. К сожалению, до сих пор у нас пока ещё не создано специальных научных центров и специальных кафедр при вузах по философии образования. В данной статье рассматривается актуальность изучения философии образования и так же дается попытка определения сущности и задачи философии образования.

1. Антипин Н.А. Мировозренческие и методологические проблемы разработки философии образования для XXI века. ([www. auditorim.ru](http://www.auditorim.ru))
2. Гомбосүрэн Ц. Философи шинжлэх ухаан мөн үү? // Эрх чөлөө ба философи. УБ. 2004. №9
3. Гусинский Э.Н, Турчанинова Ю.И. Введение в философию образования., М., 2001.
4. "Образование в конце XX века" - материалы "круглого стола". Вопросы философии 1992. №9.
5. Савицкий И.П. О философии глобального образования., М., 1992.
6. Алексеев Н, Семёнов И, Швырев В. Философия образования. Концептуально-методологические средства анализа. ([www. URAO.RU](http://www.URAO.RU))
7. Юлина Н.С. Философия для детей. М., 1996
8. Философский энциклопедический словарь., М., 1999.